



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙТИЙН АЖ АХҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮНГЭЭС



Төвлөрүүлсэн орлогоос 3 дахин их санхүүгийн
дэмжлэг авсан нь төрийн болон орон нутгийн
өмчийн тухай хуультай нийцэхгүй байна.

Аудитын дүгнэлтээс 2023 он



"Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангаас

НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор "Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар"-ыг "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар" ОНӨААТҮГ, "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ болгон салгаж орон нутгийн төсвөөс дэмжлэг авах, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар бие даан үйл ажиллагаагаа явуулах аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгосон байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ЧИГ ҮҮРЭГ



Тус байгууллага нь нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт цэвэрлэгээ, ногоон байгууламж, авто замын арчилгааг хариуцах, хамгаалах, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг эрхлэх, хотын гэрэлтүүлгийн ашиглалтыг хариуцах гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.

НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ



Орлого тасарсан шалтгааныг судлан үзэхэд шинэчлэн тогтоосон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг 2022 оны 7 дугаар сарын эхнээс мөрдөхөөр тооцоолсон ч Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр бүртгэсэн тул шинэ тарифыг тайлант оны 9 дүгээр сараас хэрэгжүүлэн ажилласан нь төлөвлөгөө биелэгдэхгүйд нөлөөлжээ.

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



НААҮГ 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Дархан сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулаагүй

- ✗ Төв суурин газрын үерийн үс зайлуулах далан сүвгийг засварлах ажлыг үе шаттай гүйцэтгэнэ
- ✗ Хараа голын эрэг дагуух цэвэрлэгээг иргэд, ААНБ-үүдэн оролцоотойгоор зохион байгуулна
- ✗ "Цэвэр хот" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ

Төлөвлөгөөний гүйцэтгэлийг 99.8 хувийн биелэлттэйгээр тайлагнасан ч 3 арга хэмжээ хэрэгжээгүй

- ✗ Хог дахин боловсруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлж бодсоны үйлдвэр байгуулна
- ✗ Байгаль ээлтэй, нөөцийн хэмнэлтэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх, аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулна
- ✗ Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгтгэсэн бодлого төлөвлөлтэй хөгжүүлнэ



"Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангаас

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шатахуун, тос, тосолгооны материалын 420.0 сая, бараа материалын 35.0 сая, автомашины дугуй, олгой хаймар, сэлбэг хэрэгслийн 30.0 сая, урсгал засварын материал, тоног төхөрөөмжийн 32.2 сая төгрөгийн худалдан авалтыг хийжээ.

81% НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРҮҮЛАЛТ

12% ХАРЬЦУУЛАЛТЫН АРГА

7% ШҮҮД ХУДАЛДАН АВАЛТ




Үнэлгээний хороонд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулаагүй байна.



Худалдан авалтаар GPS хяналтын төхөөрөмж, түлш хэмжигчийг тээврийн хэрэгсэлд суурилуулсан нь байгууллагын түлшний зардал хэмнэгдсэн хог тээвэрлэлтийн хяналт сайжирсан зэрэг үр дүнтэй хэрэгцээнд нийцсэн худалдан авалт болжээ.

НААҮГ-ЫН 2022 ОНД ШИНЭЭР НЭМЭГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СУДАЛГАА



- Тээврийн хэрэгсэл - 1,537.9 сая төгрөг
- Барилга, байгууламж - 531.8 сая төгрөг
- Ногоон байгууламж - 111.2 сая төгрөг
- Тоног төхөөрөмж - 23.6 сая төгрөг
- Нийтийн эзэмшлийн зам талбай - 4,606.6 сая төгрөг

Аудитаар аймгийн ИТХ-ын 2022 оны 66 дугаар тогтоолын дагуу 21.6 сая төгрөгийн нарс мод, 49.0 сая төгрөгийн гацуур модыг үндсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүйг данс бүртгэлд тусгуулсан.



"Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын үйл ажиллагаа, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангаас

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН

Дархан-Уул аймгийн "Нийтийн аж ахуй үйлчилгээний газар" нь 2022 онд орон нутгийн төсөвт 889.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 2,688.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан нь цаашид орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах нөөц боломжийг судлан, үе шаттайгаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжих шаардлагатй байна.

ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Тоо: **9**



Мөнгөн дүн:
103.2
сая төгрөг



ГОЛ ЗӨРЧИЛ



Зөрчил арилгуулах **98.1** сая төгрөгийн **2** албан шаардлага




Төсөвт буцаан төлүүлэх **5.1** сая төгрөгийн **2** төлбөрийн акт



Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах **5** зөвлөмж

АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ:



1. "Дотоод хяналт, шалгалтын үр нөлөөг сайжруулж, илэрсэн зөрчлийн талаар мэдээллийн сан байгуулж, ажлын баримт материалыг архивын нэгж болгох



2. Албан хаагчдын ажлын тайлан, мэдээ цахимаар болон цаасаар байхгүй байгаа тул "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллах



3. Орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах нөөц боломжийг судлан, үе шаттайгаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжих



4. Үнэлгээний хороонд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оруулах



5. Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтыг зохион байгуулах, холбогдох, мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын 8.3 дахь заалтыг мөрдөж ажиллах



Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс тус газрын 2022 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээг 80 хувиар, Дархан сумын ЗДТГ-аас 92.5 хувиар тус тус үнэлжээ.

